



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 08

Алтай

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 42 дугаар тогтоолуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Комиссын дарга: Л.Болормаа- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Гишүүдэд: С.Эрдэнэ-Очир- Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

М.Батсуурь- ГХБХБГ—ын Ерөнхий архитектур

С.Нинжбадам- Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Г.Алтангэрэл- Аймгийн худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, хөнгөлөлттэй зээл олгоход баримтлах, төсөл сонгон шалгаруулах журам”-ыг баримтлан сонгон шалгаруулалт явуулахыг комиссын дарга /Л.Болормаа/-д даалгасугай.



ДАРГА

А.ДЭЛГЭРЖАРГАЛ